



Төрийн албан хаагчийн 2023 оны жилийн эцсийн сургалтын тайлан

2023.11.13

2023 оны эхний хагас жилд “Эрсдэлд суурилсан дотоод аудит” сэдвээр ажлын байран дахь сургалтыг 2023 оны 3 дугаар сард зохион байгуулж, албан хаагчид 100 хувь хамрагдав. Мөн улсын салбарын дотоод аудит сэдвээр Сангийн яамны зохион байгуулсан сургалтад байгууллагын 4 албан хаагч хамрагдсан. Мэргэшсэн дотоод аудиторын дунд хугацааны сургалтад 2023 оны 1 дүгээр сараас 3 дугаар сар хүртэл хамрагдсан бөгөөд тус сургалтад 4 албан хаагч хамрагдаж мэргэшсэн дотоод аудиторын эрх авсан.



Төрийн захиргаа удирдлагын хэлтсээс зохион байгуулсан “Орон нутгийн төрийн байгууллагуудын хэвлэл мэдээлэл хариуцсан ажилтнуудыг чадавхижуулах сургалт”-д 2023 оны 02 дугаар сарын 28-ны өдөр дотоод аудитор Г.Насанжаргал хамрагдсан.



Төрийн албан хаагчийн дунд хугацааны мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад байгууллагын 1 албан хаагч 2023 оны 2 дугаар сараас 5 дугаар сар хүртэл хамрагдаж, сертификатаа авсан. Алсын хараа 2050, шинэ сэргэлтийн бодлогын

сургалтад байгууллагын 5 албан хаагч 4 дүгээр сард хамрагдаж, сертификатаа авсан.



“Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам” –ын талаарх системн шинэчлэл сургалтыг Сүмбэр, Шивээговь, Баянтал сумдад 2023.04.05,06 өдрүүдэд амжилттай зохион байгуулсан. Сургалтад сумдын Санхүү албаны дарга, төрийн сангийн мэргэжилтэн, сумын ЗДТГ-ын санхүүчид бүрэн хамрагдсан. “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам” –ын талаарх, “Системн шинэчлэл сургалт”-ыг систем дээр мэдээлэл оруулах онол практикын хосолсон хэлбэрээр Л.Одонтуяа /Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч/, Л.Эрдэнэчимэг /дотоод аудитор/ нар сургалт хийлээ. Сургалтаар “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам” –ын талаарх, “Системн шинэчлэл сургалт”-ыг систем дээр мэдээлэл оруулах Засгийн Газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын хэрэгжилт “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”, холбогдох хавсралтууд, цахим системийг хэрхэн ашиглах талаар, мөн албан хаагчдад систем дээр ажиллах дэлгэрэнгүй зааварчилгаа өгөх, шинэчилсэн системээр гүйцэтгэх процессыг бодитоор туршиж хэрэглэгчдэд систем ашиглах мэдлэг, чадварыг эзэмшүүлсэн.



2023 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр “Мод тарих дэлхийн өдөр”-ийг тохиолдуулан Байгаль орчин аялал жуулчлалын газраас зохион байгуулсан “Мод, сөөг ургамлыг тарих арга зүй” сэдэвт сургалтад дотоод аудитор Л.Эрдэнэчимэг хамрагдсан.



“Төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах, төсөв, санхүүгийн удирдлагыг сайжруулах, хяналт, шалгалтаар илэрч буй зөрчлийг багасгах, нэгдсэн мэдээлэл”-тэй болох зорилгоор аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсээс зохион байгуулсан сургалтад Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, Төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудит сэдвээр дотоод аудитор Л.Эрдэнэчимэг, Г.Насанжаргал нар төрийн болон ОНӨААТҮГ-аар Газруудын дарга, ахлах нягтлан бодогч нарт арга зүйн сургалтыг 2023 оны 06 дугаар сарын 26-ны өдөр хийлээ. Тус сургалтад 62 байгууллагын 100 албан хаагч хамрагдлаа.



2023 оны 08 дугаар сарын 25-ны өдөр СУГ-ын мэргэжилтан Б.Лхагвамаагаар угийн бичиг хөтлөх анхан шатны сургалтыг авч, угийн бичиг хөтлөх мэдлэг мэдээлэлтэй болсон.



Байгууллагын дотоод сургалтыг 2023 оны 08 дугаар сарын 25-ны өдөр эрсдэлд суурилсан дотоод аудит сэдвээр СХШУБ дотоод аудитор Э.Цэлмэгбаяр, дотоод аудитын тухай ойлголт, дотоод аудитын ажлын давуу тал болон сул тал, дотоод аудитаар илэрсэн нийтлэг зөрчлүүд, цаашид анхаарах асуудал гэсэн сэдвээр дотоод аудитор Г.Насанжаргал, эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлтөөр авч болох эрүүл мэндийн үйлчилгээ сэдвээр дотоод аудитор Э.Цэлмэгбаяр нар сургалт зохион байгуулсан.



2023 оны 09 дүгээр сарын 07-ны өдөр дотоод аудитор Т.Отгонтамир байгууллагын албан хаагчдад “Албан хэрэг хөтлөлтийн сургалтыг зохион байгуулсан. Сургалтаар албан хэрэг хөтлөлтийн тухай үндсэн ойлголт, баримт бичгийн төрөл зүйл, ангилал, баримт бичиг зохион бүрдүүлэхэд анхаарах зарим асуудлууд, баримт бичгийн стандарт MNS5140-1:2021, гадагш явуулах албан бичгийг зохион бүрдүүлэх дараалал, анхаарах асуудлууд, зохион байгуулалтын зарим нэр төрлийн баримт бичгүүдийг зохион бүрдүүлэхэд анхаарах асуудлууд гэх агуулгын хүрээнд орсон.



Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулдаг 7:4:10 арга зүйн сургалтад 7 хоног бүрийн Пүрэв гарагт байгууллагын бүх албан хаагч хамрагдаж байна.

2023 оны 10 дугаар сарын 16-ны өдөр ЦХХХЯ-аас зохион байгуулж буй “Цахим ур чадвар олгох” сургалтад байгууллагын бүх албан хаагч хамрагдсан.



"Эрсдэлд суурилсан аудит хийх нь", "Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангуулах тухай" сэдвээр санхүүгийн улсын байцаагч Э.Цэлмэгбаяр, Дотоод аудитор Л.Эрдэнэчимэг нар амжилттай зохион байгууллаа. Сургалтаар нийт 63 албан хаагч хамрагдаж аргазүйн зөвлөгөө мэдээлэл авлаа. Үүнд:

10 дугаар сарын 3-ны өдөр Баянтал сумын сумын төрийн байгууллагын удирдлага, дотоод хяналтын болон санхүүгийн ажилтан албан хаагч нарт зориулсан сургалт зохион байгуулагдлаа. Сургалтад нийт 9 албан хаагч хамрагдлаа.



10 дугаар сарын 9-ны өдөр Шивээговь сумын төрийн байгууллагын удирдлага, дотоод хяналтын болон санхүүгийн ажилтан албан хаагч нарт зориулсан сургалт зохион байгуулагдлаа. Сургалтад нийт 14 албан хаагч хамрагдлаа.



10 дугаар сарын 18-ны өдөр Сүмбэр сумын ЗДТГазар, Тохижилт Сүмбэр ОНӨААТҮГазар, 1, 2, 5-р сургууль, 1, 2, 5, 6-р цэцэрлэгийн удирдлага, дотоод хяналтын болон санхүүгийн ажилтан нарт зориулж сургалт амжилттай зохион байгууллаа. Сургалтад нийт 27 ажилтан албан хаагч оролцлоо.



2023 оны 10 дугаар сарын 20-ны өдөр Швейцарийн хөгжлийн агентлагаас зохион байгуулж буй “Нутгийн удирдлагын байгууллагын албан хаагчдыг чадавхижуулах” сургалтад Санхүүгийн хяналт, дотоод аудитын албан хаагчид хамрагдаж байна.

Албаны дарга Н.Алтанцэцэг 2023 оны 10 дугаар сарын 23-ны өдөр монгол бичгийн анхан шатны мэдлэг олгох сургалтыг зохион байгуулсан. Сургалтад байгууллагын бүх албан хаагч хамрагдсан.



Авилгатай тэмцэх газраас бэлтгэсэн “Авилгын мөн чанар, шалтгаан, хор хөнөөл” сэдэвт цахим сургалтад 2023 оны 10 дугаар сарын 27-ны өдөр бүх албан хаагчид хамрагдсан.

**Авлигын мөн чанар,
шалтгаан, хор хөнөөл**



Авилгатай тэмцэх газар

11 дүгээр сарын 02-ны өдөр аймгийн ЗДТГ, Сум дундын ойн анги, “УС-ДУ” ОНӨААТҮГ, Политехникийн коллеж, Цөм сүргийн үржлийн төв, Насан туршийн боловсролын төв, БОАЖГ, Боржигин чуулга, ОНӨГ, Ахмадын хороо, Нийтийн номын сан, Боржигин өв музейн удирдлага, дотоод хяналтын болон санхүүгийн ажилтан нарт зориулж сургалт амжилттай зохион байгууллаа. Сургалтад нийт 13 ажилтан албан хаагч оролцлоо.



Тайлант хугацаанд дотооддоо 7 сургалт, мэргэшүүлэх 4 сургалт, гадагшаа чиглэсэн 8 сургалт, бусад сургалт 5, мод тарих 1 сургалт нийт 15 сургалтыг зохион байгуулж, 10 сургалтад албан хаагчид хамрагдсан байна. Мөн төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулдаг 7:4:10 арга зүйн сургалтад 7 хоног бүрийн Пүрэв гарагт байгууллагын бүх албан хаагч хамрагдаж байна.

ТАЙЛАН БИЧСЭН:

ДОТООД АУДИТОР

Г.НАСАНЖАРГАЛ